

Г.Лодой.

МУИС-ийн философийн тэнхмийн  
багш, доктор, профессор

Домгийн сэтгэлгээ ба ертөнцийг  
үзэхүй

**1. Домгийн сэтгэлгээний онцлог**

Нийгэмшлийн эхэн үеийн хүмүүн төрөлхтний ертөнцийн үзэхүйд домгийн сэтгэлгээний арга барил зонхилж байжээ. Байгаль нийгмийн юмс үзэгдлийг хүмүүнчилсэн загвараар төсөөлж байсныг гэрчлэх баримтыг дэлхийн аль ч үндэстэн угсаатны домгийн сан хөмрөгөөс олж үзэж болно. Юмс үзэгдлийн мөн чанарыг ерөнхий ойлголт, категороор илэрхийлэх танин мэдэхүйн төвшинд хүмүүн төрөлхтөн хараахан хүрээгүй байсан цаг үед мэдэрхүй болон амьдрахуйн туршлагынхаа хэмжээнд хүний үйл ажиллагааны загвараар ертөнцийг төсөөлж, овог аймгийн зохион байгуулалтын бүтэц, харилцааны хэлбэрийг бодит байдлын бүхий л хүрээнд хамаатуулан сэтгэж байсныг домгийн сэтгэлгээ хэмээн ерөнхийлөн нэрлэж болох юм.

Домгийн сэтгэлгээний арга барил, онцлогийг эрдэмтэд янз бүрээр тайлбарладаг. Домгийн дүрүүд бол түүхт хүмүүсийг бурханчилсаны үр дүнд бий болсон зохиомж болно хэмээн үздэг баримтлалыг эвгемерч үзэл гэж нэрлэдэг уламжлал буй. Тухайлбал, Б.Ринчен энэ зарчмыг баримтлан буриад домгийн Эсэгэ Малаан Тэнгэрийн дүр бол үнэн хэрэгтээ Чингис хааныг тэнгэрчилсэн хэрэг мөн гэж үзэж байв<sup>1</sup>.

Домгийн сэтгэлгээний арга барилыг хүүхдийн сэтгэлгээтэй төстэй сэтгэхүйн хөгжингүй бус хэлбэртэй холбож үзэх ёс бий. Нийгмийн хөгжлийн доод шатанд “хамт олны төсөөлөл” зонхилж байсан бөгөөд “ойлголтоор сэтгэхүйн” урьдач шатны энэхүү төсөөлөлийн хүрээнд логикийн хууль үйлчлэх бус, харин “зэрэгцүүлэн хамаатуулах” зарчимд захирагдана гэж францын философич, сэтгэл зүйч К.Леви-Брюль үзэж байв<sup>2</sup>.

Эрт үеийн хүмүүсийн сэтгэлгээнд мэдэрхүйн болон оюун ухааны талууд нэгдмэл цогцолбор байдалтай байсны илрэл болох домгийн сэтгэлгээ нь эртний

<sup>1</sup> Ринчин Б. Культ исторических персонажей в монгольском шаманстве. –В кн: Сибирь, Центральная Восточная Азия в Средние века. Новосибирск, 1975. с.188-195.

<sup>2</sup> Леви – Брюль Л. Первобытное мышление. М., 1937.

болон эдүгээгийн хүмүүний оюун ухааны нийтлэг бүтцийг тодорхойлох чухал судлагдахуун болно хэмээн структурализмын томоохон төлөөлөгч К.Леви-Строс үздэг. Түүний номлолоор, домгийн сэтгэлгээ нь хүмүүний амьдрахуйн гол зөрчлүүд /тухайлбал, үхэл, амьдрал, жаргал, зовлон гэх мэт/-ийг арилгах бус, харин эвсүүлэн зохицуулахад чиглэсэн байдаг ажээ<sup>3</sup>.

Домгийн сэтгэлгээ нь ертөнцийг тайлбарлах гэсэн зорилготой бус, харин эртний шүтлэгийн зан үйлийн хуулбар болно гэсэн үзлийг Ж.Фрейзер дэвшүүлжээ<sup>4</sup>. Энэхүү үзлийг хэл шинжлэлийн Кембрижийн сургуультанууд, тухайлбал Д.Харисон, Ф.Корнфорд, А.Кук нар уламжлан хөгжүүлжээ.

Овгийн байгуулалын загвараар ертөнцийг төсөөлөх гэсэн оролдлоготой домгийн сэтгэлгээ холбоотой гэж зарим эрдэмтэд үздэг. Байгаль тэр чигээрээ аварга том овгийн байгуулал мэтээр төсөөлөгдөж, хүн шиг аж амьдралтай, хүсэл тэмүүлэл, зорьсон үйл ажилтай, эрх мэдлийн хуваарьтай мэт эрт үеийн хүмүүст санагдаж байжээ<sup>5</sup>.

Хүмүүний сэтгэцийн доод төвшингийн ухамсарын хяналтад үл хамаарах цогцолборуудтай домгийн сэтгэлгээг холбон тайлбарлах явдал буй. Сэтгэцийн ийм цогцолборууд хүмүүст нийтлэг шинжтэй байдаг тул төсөөлөхүйг зохион байгуулагч, "категорийн" үүрэг гүйцэтгэдэг ажээ<sup>6</sup>.

Дээр тоймлон дурьдсан үзэл баримтлалуудаас үзэхэд домгийн сэтгэлгээ нь олон талтай цогцолбор бүтэц бүхий үзэгдэл болох нь харагдана. Домгийн сэтгэлгээ үүсч хөгжихөд мэдэрхүйн болон амьдрахуйн туршлага, зан үйл, оюуны соёлын уламжлал, нийгмийн орчин, сэтгэцийн үзэгдлүүд зэрэг олон хүчин зүйлс нөлөөлсөн нь дамжиггүй.

Гэвч дэлхийн янз бүрийн улс үндэстний домгийн сэтгэлгээнд нийтлэг байдаг сэтгэхүйн арга барил буюу зарчмуудыг харьцуулсан судалгаагаар тодорхойлох боломжтой юм.

Аливаа үндэстэн угсаатны домгийн сэтгэлгээнд нийтлэг байдаг зүйл бол бодит байдлыг хүмүүнчилсэн, нийгэмжүүлсэн загвараар төсөөлөх явдал юм. Үүний сацуу энэхүү загварчилсан төсөөлөлөө "хүнийсгэх" замаар тэнгэр, бурхадын тухай домгийг бүтээдэг ажээ. Домгийн сэтгэлгээний үндсэн гол арга нь "хүмүүнчлэхүй" зарчимд тулгуурлана гэж үзэж болно. "Хүмүүнчлэн-хүнийсгэх"

<sup>3</sup> Леви-Строс. К Структура мифов //Вопросы философии, 1970, № 7, Колдун и его магия// "Природа. 1974. № 7.

<sup>4</sup> Фрейзер Ж. Золотая ветвь. М., 1980.

<sup>5</sup> Мелетинский С.М. Поэтика мифа. М., 1976. Лосев А.Ф. Античная мифология: в ее исторической развитии. М., 1957.

<sup>6</sup> Фрейд З. Лекции по введению в психоанализе. М-П., 1923

нь домгийн сэтгэлгээний мэдэрхүй, төсөөлөхүйн шинжийг “хүнийсгэхүй” нь хийсвэрлэн сэтгэхүйн талыг бүрдүүлдэг болой. Иймд домгийн сэтгэлгээг мэдэрхүй, сэтгэхүйн нэгдмэл цогцолбор үзэгдэл мөн гэж үзэх нь зохистой.

Орон зай, цаг хугацаа, төлөв байдал мөн чанараараа ялгаатай зүйлсийг ижилсүүлсэн нэгийг нь нөгөөгөөр орлуулах явдал домгийн сэтгэлгээний нэгэн нийтлэг шинж байдаг. Үүнийг “чөлөөт сэлгэлтийн ” зарчим гэж нэрлүүштэй. Хүн, амьтан тэнгэрийн эрхэс болсон тухай, газар дэлхий байгаль ертөнцийг бүтээгч хүмүүн шинжит бурхад, амьтадын тухай домогт гардаг өгүүлэмжүүд чухамхүү үүнтэй холбоотой юм. Домгийн сэтгэлгээний эртний хэлбэрт ийм өгүүлэмжүүд зуршмал байдаг.

Домгийн сэтгэлгээний харьцангуй төгөлдөржсөн хэлбэр нь баатарлаг туульсийн зохиомжид илэрдэг. Хүмүүн төрөлхтөний нийгэмшилтийн эхэн үед овог, аймгийн нийтлэгийн “хамт олны ухамсар” зонхилох үүрэгтэй байсан бол хөгжлийн явцад төрт ёс тогтож, бие хүний ухамсар үйл ажиллагаа харьцангуй бие даасан шинжтэй болсны улмаас домгийн сэтгэлгээний агуулгад “нийгэмшсэн хүн” буюу “туульсын баатрууд”-ын үйл ажиллагааны өгүүлэмж зонхилох болжээ. Энэ үеийн домгийн сэтгэлгээ нь уран сайхны зохиомжит хэлбэртэй цогцолбор болсноороо онцлогтой.

Баатарлаг туульсийн зохиомжийн үндсэн арга нь “бодгаль хүмүүний дүрд” хүмүүний нийтлэг үнэлэмж, эрхэмлэлүүдийг шингээн домогчлох зарчимд тулгуурладаг. Сав шим ертөнц, хүн байгалийг нэгдмэл шүтэлцээт байдлаар авч үзэж хүний үйл ажиллагаа, оюун ухаан, чадавхийг өргөмжлөн магтах нь баатарлаг туульсийн ертөнцийг үзэхүйн агуулгын нийтлэг шинж байдаг. Домгийн сэтгэлгээний хөгжлийн энэ шатанд ертөнцийг үзэхүйн шашин, гүн ухаан, урлагийн хэлбэрүүд бие даасан хэлбэрээр үүсч хөгжсөн бололтой.

Төсөөлөхүйн ба ургуулан бодохуйн хуулиар ертөнцийг загварчлах домгийн сэтгэлгээний хэлбэр нь логикийн буюу сэтгэхүйн хуулиар хийсвэр ойлголтуудын тусламжтайгаар ертөнцийг загварчилдаг философийн онол сургаал үүсэх оюуны соёлын хөрс суурь болдог боловч ердийн ухамсарын төвшинд бүрэлдэх ертөнцийг үзэхүйн агуулгад домгийн сэтгэлгээний үлдэц хадгалагдсаар байдаг. Энэ утгаараа домгийн сэтгэлгээний ертөнцийг үзэхүйн агуулга нь тухайн үндэстэн угсаатны хэлний болон оюуны соёлын орчинд эдүгээ хүртэл зонхилох үүрэгтэй хэвээр байх явдал цөөнгүй тохиолдоно.

## **2. Монголчуудын домгийн сэтгэлгээ ба ертөнцийг үзэхүй**

Домог зүйн судлагдахуун болохуйц бичгийн дурсгалт зүйлс монгол хэлнээ бараг үгүй боловч хожуу үеийн түүх уран зохиолын бүтээлд монголчуудын гарал

үүсэл, ертөнцийг үзэхүйтэй холбоотой домгийн зарим өгүүлэмжийг тэмдэглэн үлдээсэн нь цөөнгүй бий. Тухайлбал, “Монголын нууц товчоо”, “Алтан товч”, “Цагаан түүх”, “Шар тууж”, “Эрдэнийн товч” зэрэг монголын түүх соёлын иш бичгүүдэд ертөнц, хүний үсэл, хаадын гарвалын тухай домгийн шинжтэй удиртгал-өгүүлэмж заавал байдаг. Амаар уламжлагдан ирсэн домгийн өгүүлэмж, эртний домгийн сэтгэлгээтэй холбогдол бүхий эх сурвалж материалыг эмхэтгэн тэмдэглэж хэвлүүлсэн бүтээл нилээд байдаг. Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын дээж зуун билэг оршивой”, Б.Ринчин “Монгол ардын аман зохиол” хэмээх цуврал эмхэтгэл, Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном нар “Монгол ардын аман зохиол дээж бичиг”, Х.Сампилдэндэв “Монгол домог” зэрэг эмхэтгэл бүтээлүүдэд монгол домог зүйн холбогдолтой материалуудыг оруулж хэвлүүлэн олны хүртээл болгосон билээ.

Монголчуудын домгийн сэтгэлгээ, ертөнцийг үзэхүйн асуудлыг тусгайлан судалсан бүтээл одоо хир үгүй боловч утга зохиол судлал, хэл шинжлэлийн салбарын зарим бүтээлд эл асуудлыг дам авч үзэж тайлбарлах оролдлого хийсэн байдаг<sup>7</sup>.

Монголчуудын аман зохиол болон бичгийн хэлээр уламжлагдан ирсэн домог зүйн холбогдол бүхий материалд орчлон ертөнц, бурхан тэнгэрийн үүсэл гарвалын тухай сэдэв бараг үгүй, харин газар дэлхий, хүний үүсэл гарал, хүн байгалийн харилцан холбогдлын сэдэв зонхилдог. Энэ нь нүүдлчдийн соёлд хүн байгалийн шүтэлцээний асуудал тулгуур тэнхлэг болж байдаг онцлогтой холбоотой байж болох юм.

Орчлон ертөнц мөнх, харин газар дэлхий, хүн амьтан үүсэл гарвалтай, өөрчлөгдөн хувьсаж байдаг гэсэн санаа монгол домгийн өгүүлэмжинд олонтаа тохиолдоно. Орчлон ертөнцийг бүхэлд нь “мөнх тэнгэр” хэмээн нэрийдэж, “үүсгэл үгүй өвсөөн үүдэгсэн”<sup>8</sup>, “хэзээ ч хувирч өөрчлөгдөхгүй, хөдөлж хөрвөхгүй”<sup>9</sup> гэж үздэг байжээ. “Мөнх тэнгэрийн сангийн ” сударт:

“Үнэмлэхүйн дээд мөнх тэнгэр

Хамгийн дээд мөнх тэнгэр

Хамаг бүгдийг заяасан тэнгэр

<sup>7</sup> С.Дулам. Монгол домог зүйн дүр /УБ. 1989/ номд монгол домог зүйн судалгааны тоймыг дэлгэрэнгүй өгүүлсэн буй.

<sup>8</sup> Поппе Н.И. Описание монгольских шаманских рукописей Института востоковедения. 1932. № 1. с.166.

<sup>9</sup> Некладов С.Ю. Мифология тюркологический сборник М., 1981. с. 189

Хөдлөх бүгдийг заяасан тэнгэр"<sup>10</sup> гэсэн өгүүлэмж бий.

Энэ өгүүлэмжээс үзэхэд орчлон ертөнц бол оршиж буй бүх юмс үзэгдэл тэдний хөдөлгөөн өөрчлөлтийн эх сурвалж бүтээгч хүчин мөн гэсэн пантейст маягийн санаа агуулагдаж байна. “Мөнх тэнгэрээс заяаж төрсөн”, “мөнх тэнгэрийн хүчин дор” гэх мэтийн өгүүлэмж нь орчлон ертөнцийн хүчний бүрдэл болсон гэсэн утгыг агуулна. Гэвч монгол домгийн өгүүлэмжид гардаг “мөнх тэнгэр” гэдэг ойлголт нь сүсэг бишрэлийн болон бэлэгдлийн талыг давхар агуулдаг. Ертөнцийг хүнчлэн төсөөлөх домгийн сэтгэлгээний нийтлэг зарчмаар “мөнх тэнгэр” хэмээх ойлголт нь “ертөнцийн эзэн” гэсэн утгаар тэр үед хэрэглэгдэж байсан бололтой. Чухамдаа энэ утга нь “хүмүүнчлэн-хүнийсгэх” сэтгэлгээний арга барилын үр дүнд бий болжээ.

Монгол домгийн сэтгэлгээний эхэн үед “газар”, “тэнгэр” гэсэн хоёр үүтгэлийн холбооноос юмсын үүсэл, гарлыг төсөөлөх хэлбэр зонхилж байна. Энэ нь гэр бүлийн харилцааны загвараар ертөнцийг төсөөлөх гэсэн оролдлого мөн. Монгол домгийн ихэнх өгүүлэмжид “газар эх”, “тэнгэр эцэг” гэсэн санаа нийтлэг байдаг. Эл хоёр үүтгэлийн бэлэгдэл нэр нь “Эх Этүгэн”, “Эрхэт мөнх тэнгэр” болно. “Эрхэт мөнх тэнгэр” бол “Мөнх тэнгэр”-ийн бэлэгдэл нэрийн нэгэн хувилбар юм. Монголчууд домгийн сэтгэлгээний эхэн үед эр эмийн харилцааны загвараар ертөнцийг төсөөлөх хэлбэр зонхилж байсан бол хөгжлийн тодорхой шатнаас овгийн байгуулалын загвараар “нийгэмжүүлэн-хүнийсгэх ” зарчмаар ертөнцийг төсөөлөх болжээ. Үүний үр дүнд тэнгэрийн олон нэрийтгэл бий болж орчлон ертөнцийг аварга том овгийн байгуулал мэтээр домгийн өгүүлэмжид дүрсэлдэг.

Монгол бөө мөргөлийн “ерөн есийн тэнгэр ” бол “нийгэмжүүлэн хүнийсгэсэн” ертөнцийн загвар юм. Ертөнцийн хэвтээ тэнхлэгээр найман зүгийн орон, босоо тэнхлэгээр доод, дунд/төв/, дээд гэсэн гурван зүгийн орон бүгд арван зүгийн арван нэгэн оронд ангилж орон бүрийн найман зүг болон төвийг эзлэн суугч есөн тэнгэр байдаг мэтээр загварчлан төсөөлдөг. Орон зайн зүгийн энэ хуваарийг бэлэгдэл, эрхэмлэлийн зүйлстэй нь харгалзуулан шүтэлцүүлбэл эртний монголчуудын ертөнцийг үзэхийн өвөрмөц тогтолцооны загварыг олж харж болно.

Монголчуудын зүгийн бэлэгдэл ертөнцийг хүнчилсэн загвартай холбоотой үүсчээ. Хүний баруун зүүн гар хөлний үүрэг чадавхи ялгаатай байдаг, учир

<sup>10</sup> С.Дулам. Монгол домог зүйн дүр. УБ. 1989. с. 66-67 дахь тал.

монголчууд баруун талыг зөв тал, зүүн талыг буруу тал гэж нэрлэдэгээс үлбаатай. Сайн үйлийг бүтээхүйг ивээн тэтгэгч тэнгэр нэрийг баруун зүгт, буруу муу үйлийн сахиус болсон тэнгэр нэрийг зүүн зүгт байрлуулан төсөөлж байжээ. Монголчууд цагаан өнгөөр сайн сайхныг, хар өнгөөр муу муухайг бэлэгдэн үздэг. Эрхэмлэлийн зүгийн бэлэгдэлтэй хослуулбал баруун зүгийн тэнгэр нэр голдуу цагаан цайвар өнгө зүстэй, зүүн зүгийн тэнгэр нэр бараан, хар өнгө зүстэй болж дүрслэгдэнэ. Тухайлбал баруун зүгийн эзэн “баатар цагаан тэнгэр”, зүүн зүгийн эзэн “зүрхэн хар тэнгэр” гэж монгол домгийн өгүүлэмжинд гардаг.

Тэнгэр нэрийн тухай домгийн өгүүлэмжид зүг болон өнгийн бэлэгдэлийн сацуу монголчуудын аж амьдрал, үйл ажилгааны эрхэмлэл тод илэрдэг. Цаг агаар дулаан, хур бороо элбэг байхыг хүсэх, хүн шударга эрэлхэг баатарлаг тэмцэгч байхыг, эрхэмлэх мал сүрэг элбэг баян, аз жаргалтай амьдрах тэмүүлэл зэрэг нь нүүдлийн иргэншлийн эерэг үнэлэмжит эрхэмлэл болж байна. Энэ нь сайн сайхны бэлэгдэл болох баруун зүгийн тэнгэр нэрийн дүрслэлд тусгалаа олсон байдаг. Баруун зүгийн 55 тэнгэрийн нэрийн тухай домгийн зарим өгүүлэмжээс үүнийг олж үзэж болно. Тухайлбал, Наранд улаан Тэнгэр, Хуртай гурван Тэнгэр, Шударга цагаан Тэнгэр, Гал галайхан Эх тэнгэр, Элбэгжих тэнгэр Заяаган цагаан тэнгэр, Баатар тэнгэр, Дайны цагаан тэнгэр, Хишиг тэнгэр гэх мэтийн нэрийтгэл буй. Зүүн зүгийн тэнгэр нэрийг их төлөв сөрөг үнэлэмжит эрхэмлэлүүдээр нэрлэсэн байдаг. Тухайлбал, Атаа улаан Тэнгэр, Цусан гол Тэнгэр, Гурван салхин Тэнгэр, Хайр хар Тэнгэр, Балай хар Тэнгэр, Зүрхэн хар тэнгэр гэх мэтээр нэрлэдэг<sup>11</sup>. Энэ бүхнээс үзэхэд эртний монголчуудын домгийн сэтгэлгээнд эр эм үүтгэлийн эцэг эхийн баримдлагат ёсны загвараар ертөнцийг “хүмүүнчилэн-хүнийсгэж” ерөнхийлөн төсөөлж байсан бол хожуу үеийн домгийн сэтгэлгээнд “хүмүүнчлэх” хандлага хадгалагдсаар байсан хэдий боловч нийгмийн эрхэмлэл, орон зай, зүг, өнгөний бэлэгдэл, үнэлэмжийн хуваарь зэргийг хослуулсан загвараар ертөнцийг “нийгэмжүүлэн-хүнийсгэн” төсөөлж байжээ. Энэ үеийн домгийн сэтгэлгээнд хийсвэрлэхүйн чадвар улам илүү үүрэг гүйцэтгэх болсон нь харагдана.

Эртний монголчуудын ертөнцийг үзэхүйн загварт “дээд мөнх тэнгэр” нь бусад тэнгэр нэр болон бүх ертөнцийн эзэн болж дүрслэгдэнэ. Л.Хурцбаатарын тэмдэглэсэнээр: “Атаа Тэнгэр бол их эрт үед “дээд Мөнх Тэнгэр” –ийн заяагаар хан хурмаст тэнгэртэй хамт ерэн есөн тэнгэрийг захирч байжээ. Тэгэхэд тэр

<sup>11</sup> Л.Хурцбаатар. Хатагин арван гурван Атаа Тэнгэрийн тайлга /Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1992/ номд үзнэ үү.

хоёрын аль ч муу сэтгэл гэж үгүй байгаад зуу дугаар тэнгэр "Цэгээн цэвдэг Тэнгэр"-ийг бие биедээ оруулж авахын тулд зөрчилдөж эцэст нь "Хан хурмаст тэнгэр" нь "Атаа улаан тэнгэр" - ийг ялж муу зүгийн эздийг эзлүүлэх болгосон юм. Үүний улмаас "Атаа тэнгэр" нь "Хан хурмаст тэнгэр"-т атаархах болжээ<sup>12</sup>. Энэ өгүүлэмжид ерөн есөн тэнгэр нь "Мөнх тэнгэр"-ийн ивээлд байсан хэдий боловч өөр хоорондоо зөрчилдөж баруун зүүн гэсэн хоёр бүлэг болсон мэтээр дүрсэлж байгаа нь ертөнцийн "тэнгэрчилсэн загвар төсөөлөл" нь овог, аймгийн байгууллын үеийн нийгмийн харилцааг "хүнийсгэн-хийсвэрлэсний" үр дүн болохыг гэрчилнэ.

Эртний монголчуудын домгийн сэтгэлгээ нь "хүмүүнчлэн-хүнийсгэх" болон "нийгэмчлэн хүнийсгэх" зарчмын зэрэгцээ "чөлөөт сэлгэлтийн зарчимд" тулгуурлаж байсныг гэрчлэх баримт цөөнгүй бий. Тэнгэрийн эрхэс, нар сар од гаригийн үүсэл гарвалын тухай домгийн өгүүлэмжээс ийм баримт олныг олж үзэж болно. "Нар", сарыг "Өргөн Дэлхий" авдартаа түгжээд ертөнц дахин харанхуй болохын хамтаар "Өндөр Тэнгэр" есөн хүвүүн, есөн охины хамтаар олон саадыг даван туулж, уран арга хэрэглэж олж авсан тухай<sup>13</sup> домгийн өгүүлэмж байдаг. "Тэнгэрийн заадал/зам/ бол дээр цагт үй түмэн хүн, цэрэг, баруун зүг аян дайн нүүдэл хийж яваад нэг хэсэг нь дээд тивд гараад явчихсан юм гэдэг. Тэгээд тэр олон малын зарим нь огторгуйд шөнө тодрон харагддаг" гэсэн домгийн хувилбарыг Б.Ринчин тэмдэглэсэн буй.<sup>14</sup> Гурван марал од бол Хөхдэй мэргэний хөөж явсан гурван марал тэнгэрт гарснаас үүссэн, Алтан гадас бол Хөхдэй Мэргэний морины аргамжийн гадас юм гэх мэтийн домгийн өгүүлэмж цөөнгүй байдаг. Энэ бүхэн бол хүн, амьтан тэнгэрийн эрхэс, од гаригийг хооронд нь "чөлөөтэйгээр сэлгүүлэн орлуулж" ертөнцийн тогтолцоог тайлбарлах сэтгэлгээний арга барилын илрэл мөн. Үүний зэрэгцээ ертөнцийг "хүмүүнчлэх", "амьдчилах" зарчим ч дээрх домгийн өгүүлэмжүүдэд мөн агуулагдаж буй нь харагдана.

Ердийн хүний үйл ажиллагааны урлан бүтээх чадварыг "хүнийсгэн хийсвэрлэж" хүн, амьтан, газар дэлхийг үүсгэн бүтээсэн домгийн баатруудын дүрийг бүтээх ёс монголчуудын домгийн сэтгэлгээний бас нэгэн арга барил болж байв. Газар дэлхийн үүслийн тухай монгол домгийн өгүүлэмжид нийтлэг байдаг нэгэн зүйл бол газар дэлхийг үүсгэн бүтээхээс өмнө эх захгүй усан далай

<sup>12</sup> Мөн тэнд 65 дахь тал.

<sup>13</sup> Хангалов М.Н. Балаганский сборник: /сказки, поверья и некоторые обряды у северных бурят/. Томск., 1903.

<sup>14</sup> С. Дулам. Монгол домог зүйн дүр. УБ., 1989. 109 дэх тал.

байсныг ертөнцийг туурвигч тэнгэр өөрийн туслагчаар далайн ёроолоос шороо авчруулан газар дэлхийг бүтээсэн тухай дүрслэл юм. Газар дэлхийг туурвин бүтээгч тэнгэр, түүний туслагчийг янз бүрээр нэрлэх нь тохиолдох боловч агуулга нь адил байдаг.<sup>15</sup> Ертөнцийн анхдагч мах бодь, ус, шороо, хий, гал зэргийг ашиглан “Туурвигч Тэнгэр” газар дэлхийн бүтээсэн хэмээх загвараар газар дэлхийн үүслийг эртний монголчууд төсөөлж байжээ.

Хүний урлан бүтээх үйл ажиллагааны загвараар газар, дэлхий, хүн амьтан ургамлын үүсэл гарвалыг төсөөлж байсныг гэрчлэх домгийн өгүүлэмжийг М.Н.Хангалов тэмдэглэж хэвлүүлсэн буй. Энэ домогт: “Шибэгэнэ бурхан, Майдар бурхан, Эсэгэ бурхан гурав хар шороо, улаан шороо, элс гурвыг усан дээгүүр цацаж газар үүсгээд, газар дээр нь мод ногоо ургажээ. Дараа нь тэр гурав хүнийг урлажээ. Биеийг нь улаан шороогоор, ясыг нь чулуугаар, цусыг усаар бүтээжээ. Энэ гурав эхлээд эр эм хоёр хүн хийсэн ажээ.” гэж өгүүлдэг.<sup>16</sup> Монгол домгийн янз бүрийн хувилбарт “урлан бүтээгчийг” өөр өөрөөр нэрлэх явдал тохиолддог нь домгийн өгүүлэмжийн хэлний орчин цаг үеийн нөхцлөөс шалтгаалан өөрчлөгдөж ирсэнтэй холбостой юм. Хожуу үеийн Монгол домгийн өгүүлэмжид эртний домгуудад гардаг “туурвигч тэнгэр” нэрийг буддын шашны домгийн “бурхад”-аар орлуулан илэрхийлдэг ёс бий.

Хүрээлэн буй байгаль орчиныг үүсгэн бүтээгч нь “туурвигч тэнгэр” нэр боловч байгаль өөрчлөгдөн хувьсаж байдаг гэсэн үзэл санаа эртний монголчуудын ертөнцийг үзэхүйд агуулагдаж байжээ. Тухайлбал,

“Газрын өвс сая тогтож  
Галын хүй сая улайж  
Сүн далайг шалбааг байхад  
Сүмбэр уулыг товцог байхад  
Нар сая мандаж байхад  
Навч сая дэлгэрч байхад  
Сар сая мандаж байхад

Сахилдаг сая хөхөрч байхад<sup>17</sup> гэсэн уран зохиомжид өгүүлэмж нь Монголчуудын домгийн сэтгэлгээнд хувьслын үзэл санаа агуулагдаж байсныг гэрчлэх нэгэн жишээ болно.

<sup>15</sup> Мөн тэнд. 119-133 дахь талд үзнэ үү.

<sup>16</sup> Хангалов М.Н. Мифы космогонические и этнологические. Соб. Соч. 1960. т.3. с.9

Нийгмийн дотор эрх мэдлийн ялгаа эзэмшлийн хуваарь зэргээс үүдсэн зөрчил, тэмцэл явагдаж байсныг монгол домогт тэнгэр нэрийн зөрчил болгон дүрслэн өгүүлдэг.” Монгол домгийн эсрэг талын нэгэн гол баатар чэтгэр/буриад домогт Архан шүдхэр, алтай домогт Эрлэг/ бол угтаа ертөнцийг үүсгэн бүтээгчдын нэгэн бөгөөд сансар ертөнцийн үүслийн домогт өгүүлж байгаагаар газар дэлхийг бүтээлцсэн боловч өөрт хувь оногдоогүйн улмаас гомдож муудалцсан гэдэг”<sup>16</sup> ажээ. Баруун болон зүүн зүгийн тэнгэр нэрийн эзэд “Хан хурмаст Тэнгэр”, “Атаа улаан Тэнгэр” хоёр зуудугаар тэнгэр болох “Цэгээн цэвдэг Тэнгэрээс болж зөрчилдөн тэмцэлдсэн тухай өмнө дурьдсан домгийн өгүүлэмжид эрх мэдэл, эзэмшлийн төлөө тэмцэл зөрчлийг тэнгэр нэрийн зөрчил мэтээр дүрсэлсэн байдаг.

Товчоолон өгүүлбээс, монголчуудын домгийн сэтгэлгээний эхэн үед “Тэнгэр”, “Газар”-ыг эр эм үүтгэл болгон ертөнцийн үүсэл гарвалыг төсөөлж байсан зарчимд хожим нь “арга, билиг ” хэмээн нэрийдэх болсон Монголчуудын гүн ухааны сэтгэлгээний тулгуур зарчмын үндэс агуулагдаж байсан бололтой. Бодит байдлын юмс үзэгдлийг эсрэгцүүлэн шүтэлцүүлэх, зэрэг сөрөг үнэлэмжийн хувиараар сэтгэх ёс эртний домгийн сэтгэлгээнээс улбаатай ажээ. Нөгөөтэйгүүр, байгалийн юмс үзэгдлийг үүсэл гарал бүхий, мөн бус, хувьсанга чанартай болохыг төсөөлж байсан домгийн сэтгэлгээ нь нүүдэлчдийн аж ахуй, амьдрал үйл ажиллагааны хэлбэр нь байгальтай нягт уялдаатай байсны учир шалтгаантай холбоотой үүсэн бүрэлджээ гэж үзэж болох талтай. Юмсын мөн чанарыг тайлбарлахын тулд тэдгээрийн үүсэл гарлын тухай өгүүлэх “хүмүүнчлэн-нийгэмжүүлсэн” загвараар төсөөлөх, “хүнийсгэн” хийсвэрлэж тэнгэр, бурхадын тухай домгийг бүтээх ёс нь дэлхий дахины бүх үндэстэн угсаатны домгийн сэтгэлгээнд нийтлэг байдаг арга барил болой. Харин домгийн өгүүлэмжийн зохиомж нэрийтгэл загварчлалын бүтэц, хэлбэр зэрэг нь ялгаатай байдаг билээ.

Ийм эртний хүмүүн төрөлхтөний ертөнцийг үзэхүйд нийтлэг байдаг зүйлсээс өөр зүйлийг монголчуудын домгийн сэтгэлгээнээс эрж хайх шаардлагагүй бөгөөд харин тэрхүү нийтлэг сэтгэцийн арга барил нь монголчуудын сэтгэлгээнд ямар онцлог хэлбэрээр илэрч буй, хэл болон соёлын орчинтойгоо хэрхэн холбогдож байсан зэргийг тодруулах нь монгол домог зүйн судалгааны гол зорилт болно.